

ДЭЛХИЙ ДАЯАРХ УРАН БҮТЭЭЛЧДЭД ӨГӨХ УРИЛГА

Таныг Ютагийн Солт Лэйк Сити дэх Сүмийн түүхийн музейгээс ивээн тэтгэдэг 12 дахь удаагийн олон улсын уран бүтээлийн уралдаанд бүтээлээ илгээхэд урьж байна.

Уран бүтээлийн бүхий л арга барил, хэв маяг, соёл уламжлалыг хүлээн авна. Сонгогдсон бүтээлүүдийг Сүмийн түүхийн музейд болон онлайнд байршуулах болно.

Хожмын үеийн гэгээнтнүүдийн чанартай уран бүтээлийг дэмжих, Хожмын үеийн гэгээнтэн урлагийн бүтээлүүдийн цар хүрээ, нэр төрлийг сурталчлан харуулах, Сүмийн түүхийн музейн цуглуулгыг арвижуулахын тулд дэлхий даяарх уран бүтээлчдийн бүтээлийг энэхүү шүүгчдийн шийдвэрээр шалгаруулах уралдаанд хүлээн авдаг юм.

- Сэдэв: “Бурханд бүгд адил,” 2 Нифай 26:33-аас сэдэвлэсэн
- Илгээх огноо: 2021 оны 2-р сарын 1-ээс 6-р сарын 1 хүртэл
- Нас: Уран бүтээлчид 18 ба түүнээс дээш настай байх ёстой
- Шагнал: Үзэсгэлэнд оролцохоор сонгогдсон бүтээлийн уран бүтээлчдэд 2021 оны 10-р сард хариуг нь мэдэгдэх болно
- Үзэсгэлэн болох огноо: 2022 оны 3-р сараас 10-р сар хүртэл

Уралдааны дэлгэрэнгүй дүрэм, тавигдах шаардлага, онлайн бүртгэл болон өнгөрсөн уралдаануудын шилдэг бүтээлүүдийг [ChurchofJesus Christ.org/artcompetition](http://ChurchofJesusChrist.org/artcompetition) вэбсайтаас үзнэ үү. ■



“[Их Эзэн] хүмүүний үрсийн дунд сайн болох түүнийг л хийдэг; мөн тэрээр хүмүүний үрсэд тодорхойгоос бусдаар юуг ч үл хийнэ; мөн тэрээр тэднийг бүгд өөрт нь ирж мөн өөрийнх нь сайн сайхныг хүртэхийг урьдаг; мөн тэрээр хар ба цагаан, боол ба чөлөөт, эр болон эм, түүнд ирэх хэнээс боловч үл татгалздаг; мөн тэрээр үнэн Бурханыг мэддэггүй хүмүүсийг ч санадаг; мөн Бурханд бүгд адил, Иудей болон Харь аль аль нь буюу.”

—2 Нифай 26:33



Бурханд бүгд адил



戊戌年春
素娟